



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/574

Ховд

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд газрын төлбөр, татвар төвлөрүүлэх ажил хангалтгүй байгаатай холбогдуулан газрын төлбөрийн биелэлтийг давуулан биелүүлэх зорилгоор “Газрын төлбөр төвлөрүүлэх сарын аян”-ыг 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж явуулсугай.

2. Хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төвлөрүүлж ажиллахыг бүх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/, Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Батцэцэг/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zax-A/574-Da

09 02867